

ДАЛАЙ БАГШАА ДУРСАН НЬ БУЮУ ХҮМҮҮСИЙН БАХАРХАЛ

Д.Өлзийбаяр*

Чулууны Далай гэж захчин гаралтай, хятад судлаач, академич, доктор, профессор, дипломатч хүн байсныг би таних, мэдэх юм. Намайг ХЗХ-д хорин хэдтэй очиж байхад Далай гуай Түүхийн хүрээлэнд эрдэмтэн нарийн бичгийн дарга, захирал, дөч эргэм насны хүн байв. Хэдийнээ дэд эрдэмтэний зэрэг хамгаалсан гэж ярилцана. Бидэнд хятадын улс төрийн асуудал ялангуяа тэр үед ихэд яригдаж байсан соёлын хувьсгалын асуудлаар яриа таниулга байнга хийнэ. Намайг Увсын Сагилынх гэдгийг мэдмэгцээ "...муу дөрвөдөөр сонин юу байна, сонин хэвлэл бараг алгасахгүй бичих юмаа. Ёстой л "Довтолдогийн" хөвүүн мөн юмаа л гэнэ. Та яаж манай аавын хочийг мэдсэн юм бэ? гэхэд би чинь далдыг мэддэг Далай гэдэг хүн шүү дээ" гэж алиалах аядана. Харин саяхан Далай багшийн 80 насны ой болж найз нөхөд, шавь нар нь хурал хуй ч хийв. Ном судар ч гаргав. Тэгэхээр би хүндэтгэж явдаг эрдэмтнийхээ тухай "Эрдмийн Далай" (2010) номын талаар цөөн үг дурдсу.

Эрдэмтэн Далай. Далай багш түүхийн судлалаар том эрдэмтэн байж. Тэр хар залуудаа Буриадын Дорж Банзаровыг эс тооцвол хэний ч зүрхлэн барьж авч чадаагүй асар ярвигтай сэдэв бөө мөргөлийн асуудлаар анхны номоо бичжээ. Түүний бүтээл туурвилыг олон эрдэмтэн тал бүрээс нь судлажээ. Тэрбээр монгол хэлээр зуу орчим ном, хятад хэлээр 174, япон хэлээр 28, орос хэлээр 94, баруун европын хэлнүүдээр (англи голдуу) 52 номыг нийтдээ бараг хагас мянган нэр төрлийг түүхэн судалгаа, угсаатны судалгаа, соёл иргэншлийн өргөн сэдвээр заан дурджээ. Зөвхөн нэрсийг нь хөөж уншихад л цаана нь Монголын Юан гүрний үеийн түүхээр унших ном бараг үлдээгүй гэдэггүй юмаа гэхэд хамгийн гол тулгуур мэдлэгийн эх булгийг шавхах нь тэр болох ажээ (Л.Түдэв. "Эрдмийн Далай") "Юан гүрний үеийн Монгол", "Монгол, Хятадын харилцаа", "XIII-XIV зууны Монгол", "Монгол Ойрадын түүх" зэрэг олон чансаатай ном туурвисан Монгол Улсдаа төдийгүй дэлхийд нэртэй, данстай энэ эрдэмтэн маань одоо ч амьд сэрүүн байгаа мэт эрдмийн ажлын хувьд, бүтээл туурвилын хувьд бид бүхэнд хамгийн шилдэг үлгэр дууриал болсоор, бид бүгдийн бахархал, урам зоригийг бадраасаар байгаа билээ. (доктор Л.Хайсандай. "Академич Ч.Далай бол Монголын түүх, дорно дахины судлалын тэргүүлэх эрдэмтэн байсан юм")

Ч.Далай гуай олон арван бүтээлээрээ монгол үндэстэн бүрэлдэн тогтох үйл явц, Монгол Улс байгуулагдсан он цагийг тодотгох, нэршлийг тогтоох, Хамаг Монгол улс, Их Монгол улс, Юан гүрний үеийн Монгол Улсын түүхийг тодруулах, түүхийн шинэ үзэл баримтлал, шинэ хандлага, шинэ сэтгэлгээг бий болгон Хятадын болон гадаадын түүхэн эх сурвалжийг судалгааны эргэлтэнд оруулсан нь Монголын түүхийн 5 боть зохиол, бусад олон арван нэгэн сэдэвт зохиол, сурах бичигт нэн тодорхой байр сууриа

* Д.Өлзийбаяр - доктор (Ph.D), профессор

эзлэж чадсан билээ. (Л.Бэгзжав. Дэлхийд данстай хятад судлаач, академич Ч.Далай)

“Академич Ч.Далай бол түүхэн учиг баримтаас ургуулан бодож, сонирхолтой гаргалгаа дүгнэлт хийж чаддаг нэртэй эрдэмтэн байв” (Ж.Болдбаатар. Далай шиг эрдэмтэй Далай багш) гэх мэтээр тодорхой баримт түшин үнэлсэн байна.

Бас Япон, Хятадын олон эрдэмтэн Далай гуайн бүтээл туурвил, эрдэм судлалын нөр их ажлыг нь өндрөөр үнэлж дүгнэснийг энэ номоос үзэж болно.

Далай багш. Далай гуай эрдэмтэн хүнийхээ хувьд МУИС зэрэгт хичээл зааж байж. Академич Болдбаатарын өгүүлснээр “-----” 1967 онд МУИС-д элсэн орж, “Бөө мөргөлийн түүх” номоор нь Ч.Далай багшийг эцнээ таних болсон юм. Харин төгсөх курсэд Ч.Далай багш “Монгол Улсын түүх”-ийн тусгай курсээр “Монголын Юан улс”-аар 8 цаг, “Бөө мөргөл”-ийн түүхээр 4 цагийн хичээл зааж билээ”. Ийм явдал олон тохиолдсон нь мэдээж. Бас олон хүний эрдмийн ажлыг удирдаж халуун дотно зөвлөгөө өгч тусалж дэмждэг нэгэн байж. Ямартаа ч доктор Ц.Баатарт үүрэг даалгавар өгч “Монголын өвгөч овог Урианхан” хэмээх өгүүлэл бичүүлж нэрт угсаатны зүйч С.Бадамхатангийн эндүүрлийг арилгуулсан байх жишээтэй.

Дипломатч Далай. Далай гуайг би Бээжингийн их сургуулийн түүхийн анги төгссөн, дундаа завсарлагатай 2 ч удаа дипломат ажил хийж байсан гэж сонссон маань энэ номоос ажихад тодорхой болов. Үүнийг доктор Л.Бэгзжавын бичсэнээс “Мөн хоёр дахь удаагийн дипломат томилолтоороо 1986-1989 онд дахиад л БНХАУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-ны 1-р нарийн бичгийн даргаар ажилласан юм. Энэ үед Монгол-Хятадын өнөөгийн найрсаг харилцааны олон эхлэлийг тавихад Далай багш гар биеэрээ оролцсон юм. Хятадад ийнхүү 15 жил сурч, ажиллаж амьдрахдаа Хятад орны амьдралыг нэвтэрхий мэдэж, хятадын түүх, хятад судлалын талаар улсдаа тэргүүлэх эрдэмтэн болсон байна” гэснээс мэдэж болно. Нөгөөтэйгүүр Ч.Далай гуай өөрөө “Дипломат албанд зүтгэсэн он жилүүд” хэмээх сайхан дурдатгал бичиж үлдээсэн нь дипломат хүний баяр жаргал, зовлон бэрхшээлийг бодитойгоор тодорхойлно. Тэрбээр ахмад дипломатч М.Дүгэрсүрэн гуайгаас “Чи залуу хүн ажил сайтай, ам бөхтэй бай! Гэхдээ дипломат хүн бол хүнд юм ярьж өгч байж хүнээс үг сонсдог юм. Харин ярих юмаа урьдаас сайн төлөвлөн бодож бай” гэсэн алт шиг сургаалийг сонсож, өвгөн Олдох гуайн үнэн сэтгэлийн үгийг хүлээн авч биелүүлж явсан байна. Мөн соёлын хувьсгалын шуурган гал дунд Хятадуудын зүгээс үзүүлсэн хатуу бэрх оmtгойдлыг даван туулж байснаа өгүүлсэн нь нэгэн цагийн түүхэн баримт болон харагдаж байна.

Хүнлэг Далай. Далай гуай өөрийн үзэл бодолдоо туйлбартай ханддаг хүн байж. Үүнийг нь “...Чингис хааны онгон хаана байгааг Х.Пэрлээ багш мэддэг байсан. Надад ч газрын багцаа зааж өгсөн. Гэхдээ энэ нууцыг задруулах ёсгүй юм. Ер нь түүнийг хайгаад байх хэрэггүй юм. Магадгүй хэдэн жилийн дараа олдох биз. Олдлоо гэхэд бас олон сөрөг үр дагавар гарч мэднэ” гэх буюу “Миний амьдралд тохиосон тун сайн хүмүүсийн нэг

нь Ю.Цэдэнбал гуай байсан юм. Би түүхч хүний хувьд түүний хийж бүтээсэн зүйл, үзэл бодлыг нь үнэхээр эх орныхоо төлөө гэсэн бодол санааг агуулж байсныг бат ноттой хэлж чадах байна. Цэдэнбал гуайн хийж бүтээсэн бүх зүйлийг түүх мартах ёсгүй” гэж шулуун шударга, ил тод өгүүлсэн байх юм.

Далай гуайн өгөөмөр дэлгэр, өрөвч нинжин сэтгэл нь шавь нарынх нь дурдатгалаас нэн тодорхой. Үүнд доктор Ц.Баатар “Залуу хүн алдаж онолгүй яахав, бид ямар залуу яваагүй биш тэр муугийн буруу гэж юу байхав. Көөркээ амьтан хөл гараа олж амьдрах гэж ядаж яваа юм гэж бусдаас өмөөрч хамгаална. Сайн хүүхэд байгаа юм. Тэрүүний араас би явахгүй юм бол хэн явах вэ л гэнэ”, эрдэм шинжилгээний ажилтан, орчуулагч Б.Сэржав “Хэнийг ч болов хувь хүнийх нь төдийгүй, нутаг усных нь сайн сайхан талыг олоод хэлчихдэг зантай. Багшийн тэр чанар нь өөрийгөө, эцэг эхээ магтуулахаас илүү нутаг хошуугаа сайнаар хэлүүлэх дуртай монгол хүн бүхэнд сайхан сэтгэгдэл төрүүлдэг байсан. Намайг Дундговийнх болохоор “Төв Халхын боржигоньхон, Дундговийнхон жинхэнэ халхууд” гэнэ. “Танай нутгийн тийм хүнтэй танилцлаа. Яриа хөөрөөтэй сайхан залуу байна” гээд л ярих” гэх зэргээр бичсэнээс харж болно.

Ийм жишээ бараг бүх өгүүлэл, дурсамжид байгааг хэлэлтэй.

Төгсгөл. Энэхүү “Эрдмийн Далай” хэмээх номд Далай багшийн охин Д.Эрдэнэ-Отгон аавыгаа мөнхийн залуу, ач хүү Ц.Энхбат өвөөгөө төлөвлөгөөгөөр биш төрөлхөөсөө заяасан эрдэмтэн хэмээн бахархан бичсэн нь гэр орондоо ч асар их нөлөөтэй хүн байсныг нь гэрчилнэ. Харин охины бичсэн “Цаашид аавынхаа бичсэн олон арван бүтээлийг арвижуулж олны хүртээл болгох тал дээр охин нь чадах чинээгээрээ зүтгэх болно” гэсэн хүсэл бодол нь биелэх болтугай гэсэн ерөөл талбия.

Мөн Ж.Болдбаатар нарын хэд хэдэн хүний бичсэнээс ойлгосон ч, энэ номд байгаа Далай гуайн бичсэн дурдатгалаас үзсэн ч Далай гуай өдрийн тэмдэглэл байнга хөтөлдөг хүн байж. Тэгэхээр үр хүүхэд, ач зээ ялангуяа эрдэмтэн шавь нарт нь тэр өдрийн тэмдэглэлийг олж олон нийтийн хүртээл болгох ажил үлдэж байгааг үгийн далимд сануулах минь.